

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2025/124/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Назгүл
Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТТӨХ	Тоног төхөөрөмж

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ДЭЛҮҮН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
С.АМАНКЕЛДИ ТАНАА

2024.02.25 № 226
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар нь 2024 онд 1,519.7 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1,459.7 сая төгрөг зарцуулж, 96.05 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын

832502000246

стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>160,111,544.98</u>	<u>82,575,181.26</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	120,131,549.98	51,543,300.01
354	Хангамжийн материал	51,631,551.98	45,708,300.01
35410	Бичиг хэргийн материал	364,702.00	270,200.00
35420	Аж ахуйн материал	8,993,299.98	7,741,900.01
35470	Бусад хангамжийн материал	42,273,550.00	37,696,200.00
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад	68,499,998.00	5,835,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	39,979,995.00	31,031,881.25
36300	Тэжээлийн нөөц	39,979,995.00	31,031,881.25
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,293,309,441.52</u>	<u>2,332,910,332.42</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,293,309,441.52	2,332,910,332.42
391	Газар		
392	Биет хөрөнгө	2,281,030,205.80	2,321,182,948.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,694,608,589.00	1,789,868,481.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(447,837,083.64)	(523,637,439.18)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	259,859,986.00	368,859,986.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(52,579,079.00)	(106,180,346.54)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	416,849,609.30	471,758,659.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(261,324,705.60)	(299,396,086.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,330,604.00	101,767,104.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(48,132,047.53)	(55,561,431.26)
39209	Зам, гүүрийн байгууламж	560,258,486.00	560,258,486.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(81,849,697.20)	(104,900,236.56)
39214	Бусад үндсэн хөрөнгө	398,996,878.74	398,996,878.74
39215	Хуримтлагдсан элэгдэл	(247,151,334.27)	(280,651,106.80)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном		
393	Биет бус хөрөнгө	12,279,235.72	11,727,384.29
39301	Програм хангамж	6,556,639.00	7,326,639.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,402,003.28)	(3,723,854.71)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,124,600.00	8,124,600.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,453,420,986.50</u>	<u>2,415,485,513.68</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	=
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,453,420,986.50</u>	<u>2,415,485,513.68</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,453,420,986.50	2,415,485,513.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	744,160,007.00	744,160,007.00
51101	Өмч: - төрийн	744,160,007.00	744,160,007.00

512	Хуримтлагдсан үр дүн	1,596,656,627.70	1,558,721,154.88
51210	Өмнөх үеийн үр дүн	1,596,656,627.70	1,596,656,627.70
51220	Тайлант үеийн үр дүн	-	(37,935,472.82)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	112,604,351.80	112,604,351.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,453,420,986.50</u>	<u>2,415,485,513.68</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,075,536,509.00	1,810,060,390.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	284,995,988.00	326,425,942.00
120	Нийтлэг татварын бус орлого	284,995,988.00	326,425,942.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	284,995,988.00	326,425,942.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	243,325,993.00	221,525,942.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	41,669,995.00	104,900,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	790,540,521.00	1,483,634,448.75
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,879,221.00	23,935,948.75
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,879,221.00	15,935,948.75
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	784,661,300.00	1,459,698,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	784,661,300.00	1,459,698,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,014,667,988.38	1,847,995,863.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,014,667,988.38	1,847,995,863.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	989,547,154.97	1,758,773,263.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	519,017,705.91	928,997,158.00
210101	Үндсэн цалин	384,659,164.91	545,429,922.00
210102	Нэмэгдэл	119,237,141.00	360,515,602.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	15,121,400.00	23,051,634.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,167,763.68	116,044,524.48
210201	Тэтгэврийн даатгал	43,914,272.63	79,335,678.02
210202	Тэтгэмжийн даатгал	5,234,177.06	9,289,971.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,678,623.93	4,644,985.99
210204	Ажилгүйдлийн даатгал	1,029,048.91	4,554,777.93
210205	Эрүүл мэндийн даатгал	10,311,641.15	18,219,110.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,939,000.00	37,046,062.99
210301	Гэрэл, цахилгаан	1,379,000.00	2,486,062.99
210302	Түлш, халаалт	35,560,000.00	34,560,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,063,960.00	131,379,092.97
210401	Бичиг хэрэг	3,816,700.00	5,262,800.00

210402	Тээвэр, шатахуун	33,165,610.00	49,075,083.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,361,200.00	2,133,000.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	697,360.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	327,000.00	210,400.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал	3,393,450.00	74,000,449.97
2105	Нормативт зардал	430,000.00	2,700,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	430,000.00	2,700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,030,000.00	5,687,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	335,000.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	71,000.00	35,200.00
210604	Урсгал засвар	2,959,000.00	5,317,100.00
2107	Томилолт, зочны зардал	8,037,200.00	11,435,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	8,037,200.00	11,435,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,614,157.00	62,101,696.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,649,000.00	60,380,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	157,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	389,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	87,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	837,650.00	981,000.00
210807	Газрын төлбөр	82,407.00	106,246.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45,100.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	285,247,368.38	463,382,428.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,591,979.00	230,349,377.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	683,900.00	258,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	209,971,489.38	232,774,551.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,120,833.41	89,222,600.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,523,200.00	15,943,276.70
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,809,200.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	14,892,276.70
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	714,000.00	1,051,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,597,633.41	73,279,323.83
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага		
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,597,633.41	73,279,323.83

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>60,868,520.62</u>	<u>(37,935,472.82)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,333,333.08	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,333,333.08	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(8,333,333.08)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>52,535,187.54</u>	<u>(37,935,472.82)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>790,540,521.00</u>	<u>1,483,634,448.75</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	790,540,521.00	1,483,634,448.75
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,879,221.00	23,935,948.75
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,879,221.00	15,935,948.75
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	784,661,300.00	1,459,698,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	784,661,300.00	1,459,698,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>771,690,521.00</u>	<u>1,432,784,948.75</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	771,690,521.00	1,432,784,948.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	746,569,687.59	1,343,562,348.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	519,017,705.91	928,997,158.00
210101	Үндсэн цалин	359,438,134.56	480,515,370.94
210102	Нэмэгдэл	144,458,171.35	426,876,416.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	15,121,400.00	21,605,370.89
210105	Гэрээт ажлын хөлс		
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,167,763.68	116,044,524.48
210201	Тэтгэврийн даатгал	43,728,063.68	79,335,678.02
210202	Тэтгэмжийн даатгал	5,360,000.00	9,289,971.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,287,900.00	4,644,985.99
210204	Ажилгүйдлийн даатгал	1,072,000.00	4,554,777.93
210205	Эрүүл мэндийн даатгал	10,719,800.00	18,219,110.96
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,939,000.00	37,046,062.99
210301	Гэрэл, цахилгаан	1,379,000.00	2,486,062.99

210302	Түлш, халаалт	35,560,000.00	34,560,000.00
210303	Цэвэр, бохир ус		
210304	Байрны түрээс		
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	54,722,010.00	57,533,843.00
210401	Бичиг хэрэг	4,090,200.00	5,295,000.00
210402	Тээвэр, шатахуун	47,765,610.00	49,075,083.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,539,200.00	2,133,000.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	697,360.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	327,000.00	333,400.00
2105	Нормативт зардал	430,000.00	2,700,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	430,000.00	2,700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,480,000.00	6,872,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	574,000.00	680,000.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	71,000.00	143,200.00
210604	Урсгал засвар	4,835,000.00	6,049,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,037,200.00	11,435,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	8,037,200.00	11,435,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,614,157.00	82,220,796.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,649,100.00	80,499,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	157,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	389,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	87,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	837,550.00	981,000.00
210807	Газрын төлбөр	82,407.00	106,246.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45,100.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,161,851.00	100,712,763.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,477,951.00	100,304,263.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	683,900.00	408,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,120,833.41	89,222,600.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,523,200.00	15,943,276.70
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,809,200.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	14,892,276.70
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	714,000.00	1,051,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,597,633.41	73,279,323.83
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,597,633.41	73,279,323.83

213404	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>18,850,000.00</u>	<u>50,849,500.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	18,850,000.00	50,849,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,850,000.00	50,849,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,850,000.00	50,849,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,850,000.00	50,849,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(18,850,000.00)</u>	<u>(50,849,500.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	744,160,007.00	112,604,351.80	1,596,656,627.70		2,453,420,986.50
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	744,160,007.00	112,604,351.80	1,596,656,627.70	-	2,453,420,986.50
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	744,160,007.00	112,604,351.80	1,596,656,627.70	-	2,453,420,986.50
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	744,160,007.00	112,604,351.80	1,596,656,627.70	-	2,453,420,986.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	744,160,007.00	112,604,351.80	1,596,656,627.70	-	2,453,420,986.50
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(37,935,472.82)		(37,935,472.82)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	744,160,007.00	112,604,351.80	1,558,721,154.88	-	2,415,485,513.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,519,698,500.00	1,386,419,176.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,519,698,500.00	1,386,419,176.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,476,516,100.00	1,370,475,899.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	938,442,500.00	928,997,158.00
210101	Үндсэн цалин	492,074,000.00	480,515,370.94
210102	Нэмэгдэл	425,623,500.00	426,876,416.17

210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	20,745,000.00	21,605,370.89
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,392,800.00	116,044,524.48
210201	Тэтгэврийн даатгал	78,795,100.00	79,335,678.02
210202	Тэтгэмжийн даатгал	9,399,400.00	9,289,971.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,699,700.00	4,644,985.99
210204	Ажилгүйдлийн даатгал	4,699,700.00	4,554,777.93
210205	Эрүүл мэндийн даатгал	18,798,900.00	18,219,110.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,060,000.00	37,046,062.99
210301	Гэрэл, цахилгаан	2,500,000.00	2,486,062.99
210302	Түлш, халаалт	34,560,000.00	34,560,000.00
210303	Цэвэр, бохир ус		
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	55,054,000.00	55,047,758.00
210401	Бичиг хэрэг	5,295,000.00	5,295,000.00
210402	Тээвэр, шатахуун	45,735,500.00	46,452,398.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,853,500.00	2,133,000.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	697,360.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	470,000.00	470,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	2,700,000.00	2,700,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,700,000.00	2,700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,135,600.00	28,135,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,943,400.00	21,943,400.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	143,200.00	143,200.00
210604	Урсгал засвар	6,049,000.00	6,049,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,600,000.00	9,565,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	9,600,000.00	9,565,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	187,404,200.00	96,067,296.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	185,027,200.00	94,346,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	513,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	184,800.00	157,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	392,000.00	389,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,400.00	87,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	981,000.00	981,000.00
210807	Газрын төлбөр	128,500.00	106,246.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	57,300.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	101,727,000.00	96,872,500.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,665,000.00	95,810,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,062,000.00	1,062,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,182,400.00	15,943,276.70
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,182,400.00	15,943,276.70
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,239,100.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,892,300.00	14,892,276.70
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,051,000.00	1,051,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,519,698,500.00	1,386,419,176.17
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,519,698,500.00	1,386,419,176.17
132001	Орон нутгийн төсвөөс	1,519,698,500.00	1,386,419,176.17
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	33.00	33.00
620001	Удирдах ажилтан	15.00	14.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	6.00
620004	Гэрээт ажилтан	5.00	3.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	33.00	33.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	8.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	8.00
650010	Гэрээт ажилтан	3.00	3.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	15.00	14.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,935,948.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,935,948.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,935,948.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-
2104	Хангамж, бараа материалын зардал	2,622,685.00
210401	Бичиг хэрэг	
210402	Тээвэр, шатахуун	2,622,685.00
2107	Томилолт, зочны зардал	1,870,000.00
210701	Гадаад албан томилолт	
210702	Дотоод албан томилолт	1,870,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,443,263.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,443,263.75
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,935,948.75
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,935,948.75
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,935,948.75
131106	Төсвийн урамшуулал	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар нь төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа эрхэлдэг чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага.

Тайлант онд “Иргэдийн оролцоонд тулгуурласан, иргэдэд ойр, уян хатан, идэвх санаачилгатай, үр дүнд чиглэсэн, төрийн захиргааны албан хаагчид төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангаж ажиллахад оршино” гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар нь Монгол Улсын үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Улсын Их хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Байгууллагын даргын 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн Б/08 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлог тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37.9 сая төгрөгөөр буюу 1.55 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага			
Бараа материал	160,111.50	82,575.20	(77,536.30)
Үндсэн хөрөнгө	2,293,309.40	2,332,910.30	39,600.90
Нийт хөрөнгө	2,453,420.90	2,415,485.50	(37,935.40)
Өр төлбөр			-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,453,420.90	2,415,485.50	(37,935.40)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,453,420.90	2,415,485.50	(37,935.40)

Мөнгөн хөрөнгө, авлагын данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 82.6 сая төгрөг болж 77.5 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 143.2 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 1.9 сая төгрөгийн гал унтраах багаж хэрэгсэл, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 102.9 сая төгрөгийн хорголжин хивгийг үнэгүй хүлээн авч, 251.6 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, сумын ИТХ-ын 2024 оны 12

дугаар сарын 20-ны өдрийн худалдааны 15 дугаар тогтоолоор 74.0 сая төгрөгийн бараа материалыг акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 39.6 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 50.8 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 106.0 сая төгрөгийн автомашин, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон 115.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэгүй хүлээн авч тайлан бүртгэлд тусгасан байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант оны үр дүнгээр 37.9 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 977.7 сая төгрөгөөр орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр, зарлагын нийт дүнг 977.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж 343.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1,320.9 сая төгрөгөөр баталсан байна. Батлагдсан төсвийг 198.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,519.7 сая төгрөгөөр тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны төсвийн хэлбэлзлийн тайлангаар зарцуулах төсөв нь 1,519.7 сая төгрөг байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,519.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,386.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,386.4 сая төгрөг буюу 91.2 хувьтай байгаа нь 60.0 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, 73.3 сая төгрөгийн санхүүжилтийг төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	896,664.20	881,479.20	15,185.00	98.31
2	Туслах үйл ажиллагааны зардал	398,597.90	398,423.80	174.10	99.96
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж	43,182.40	15,943.30	27,239.10	36.92
4	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	181,254.00	90,572.80	90,681.20	49.97
	Нийт дүн	1,519,698.50	1,386,419.10	133,279.40	91.23

Тус сумын ИТХ-ын 2024 оны 109 дүгээр тогтоолоор Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 181.3 сая төгрөгийг хуваарилсан байна.

Сумын орон нутгийн орлогын давсан хэсгээс байгаль хамгаалах санд хуваарилсан хөрөнгөнөөс “Улаан говь” нөхөрлөлийн хариуцаж байгаа газар нутагт ань амьтны судалгаа

хийх ажилд 20.0 сая төгрөгийн, “Хыдыр отог” нөхөрлөлийн хариуцаж байгаа газарт нутагт ань амьтны судалгаа хийх ажилд 20.0 сая төгрөгийн гэрээг хийж, урьдчилгаанд тус тус 10.0 сая төгрөг буюу 20.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

“Улаан говь” нөхөрлөлтэй хийсэн гэрээг цуцалж шилжүүлсэн урьдчилгаа мөнгийг буцаан авч “Агнуур судлалын нийгэмлэг”-тэй 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр 19.6 сая төгрөгийн аргаль хонь, янгир ямаанд хяналтын тооллого хийх, амьтны судалгаа хийх гэрээ байгуулж, 10.0 сая төгрөгийн урьдчилгаа мөнгийг шилжүүлжээ.

Дэлүүн сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын А/124 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр “Хыдыр отог” нөхөрлөл гэрээнд заасан ажлыг хүлээн авч үйлдсэний дагуу үлдэгдэл 10.0 сая төгрөгийг төсвөөс олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар нь ахмадын сан байгуулаагүй, аймгийн Засаг даргын тамгын газраас 6.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч ахмадын баярт зарцуулсан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажилласан байна.

Төсвөөс 2024 онд бараа үйлчилгээний бусад зардлын /210901/ төсвөөс 95.8 сая төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн /210801/ төсвөөс 94.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тус байгууллагад 2024 онд 33 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр удирдах ажилтан 14, гүйцэтгэх ажилтан 10, үйлчлэх ажилтан 6, гэрээт ажилтан 3, нийтдээ 33 орон тоогоор батлагдсан орон тоо, төсөвт багтаан ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 23.9 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч 6.0 сая төгрөгийг ахмадын баярт зарцуулж, 8.7 сая төгрөгийн өвсийг малчдад 50 хувиар тарааж, 7.0 сая төгрөгийг мал тооллогын зардалд, 1.0 төгрөгийг онцгой байдлын зардалд, 0.5 сая төгрөгийг байгаль орчны нөхөн сэргээлтийн зардал, 0.7 сая төгрөгийг сургалтын замын зардалд тус тус зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар нь 2024 онд батлагдсан төсвийн хүрээнд 143.2 сая төгрөгийн бараа материал, 50.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 03/22 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,014.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 15.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоов.

Гүйцэтгэх шатанд материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1,848.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 27.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан бөгөөд алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгасан.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 1,595.8 сая төгрөгийн 19 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 308.5 сая төгрөгийн 30 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 449.0 сая төгрөгийн 25 мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж эрсдэлтэй гэж үзсэн данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй гүйцэтгэлийн шалгалтаар шалгах шаардлагатай.

Дараагийн аудитаар байгаль хамгаалах санд хуваарилсан ан амьтны тоо толгойн судалгаа хийх, биотехникийн арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийн зарцуулалт, үр дүнг хэрхэн тооцсоныг анхаарч үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 10.0 сая төгрөгийн алдаа илэрч залруулга хийв. Үүнд:

- “Агнуур судлалын нийгэмлэг”-тэй 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр аргаль хонь, янгир ямаанд хяналтын тооллого хийх, амьтны судалгаа хийх 19.6 сая төгрөгийн гэрээ байгуулж, гэрээний урьдчилгаанд шилжүүлсэн 10.0 сая төгрөгийг санхүүгийн тайланд зардлаар бүртгэснийг урьдчилж гарсан зардлаар залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан “Төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах журам”, 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын дүнгээр 46.4 сая төгрөгийн зөрчил илэрч 16.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 29.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр 16.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв. Үүнд:

Засаг даргын тамгын газрын сахиулд тайлант онд долоо хоногийн амралтын өдөр ажилласны нэмэгдэл хөлст нийт 16,717,800 төгрөгийн цалинг олгож төрийн албан хаагчид нэмэгдэл хөлс олгох хувь хэмжээг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3.1-т “Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Аудитаар нийт 29.7 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлэв.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Байгаль хамгаалах санд хуваарилсан хөрөнгийн зарцуулалт, үр дүнтэй холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Сумын орон нутгийн орлогын давсан хэсгээс байгаль хамгаалах санд хуваарилсан хөрөнгөнөөс ан амьтны тоо толгойн судалгаа хийх гэрээний урьдчилгаанд “Агнуур судлалын нийгэмлэг”-т 10.0 сая шилжүүлсэн боловч үр дүнг тооцоогүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Ан амьтны тоо толгойн судалгаа хийх арга хэмжээнд олгосон хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, ажлын тайланг авч үр дүнг тооцох;

2. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй, Сайко инвест ХХК-аас 17.7 сая төгрөгийн, “Табигат” хоршооноос 12.0 сая төгрөгийн, нийтдээ 29.7 сая төгрөгийн хөрөнгийг шууд гэрээгээр худалдан авч, төрийн цахим худалдан авалтын журмыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.13-т “Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”, 14.4-т “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх, цахим худалдан авалтын журмыг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш **30** хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг **2025 оны 10 дугаар сарын 10-ны** өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

